

Дэлхий дахинд жил бvр БЗДХ-ын 340 сая орчим тохиолдол бvртгэгддэгийн 12 сая орчим нь тэмбvv овчин байдаг байна. Дэлхийн эрvvл мэндийн байгууллагын/ДЭМБ/ тооцоолсноор жил бvр 2 сая жирэмсэн эмэгтэй тэмбvv овчинтэй оношлогдон ойролцоогоор 12 сая ураг зулбах, амьгvй торох, нярай бага жинтэй торох зэрэг хvндрэл гардаг. Эмчлэгдээгvй буюу дутуу эмчлэгдсэн тэмбvvтэй эхээс торсон хvvхдийн 25 орчим хувь нь амьгvй буюу жин багатай торох, 25-30% нь нярай vедээ нас барах, 5 орчим хувь нь эмгэг гаж хогжил, 40 хvртлэх хувьд нь торолхийн тэмбvv овчин тохиолддог. Дэлхий дахинаа баримталж буй БЗДХ-аас сэргийлэх хянах 2006-2015 оны стратегид торолхийн тэмбvv овчнийг устгах зорилт орсон байдаг.

Монгол улсын хувьд ч Мянганы хогжлийн зорилтод хvvхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрvvл мэндийг сайжруулах, БЗДХ/ДОХ сvрьеэтэй тэмцэх тодорхой зорилтууд тусгагдсаны дотор эхээс урагт тэмбvv овчин халдварлах эрсдэлээс сэргийлэх жирэмсэн эмэгтэйчvvд болон бэлгийн хавьтагчдад чиглэсэн“Нэг цэгийн vйлчилгээ” тосол ДЭМБ, Глобаль сангийн дэмжлэгтэй 6 дvvрэгт хэрэгждэгийн 1 нь Баянгол дvvрэг юм. Уг тослийн хvрээнд торолхийн тэмбvv овчноос урьдчилан сэргийлэх vйл ажиллагааг эрчимжvvлэн жирэмсэн эмэгтэйчvvдэд vзvvлэх тусламж vйлчилгээнд хурдавчилсан сорилын аргыг оргоноор нэвтрvvлж тэмбvv овчнийг эрт илрvvлэх,эмчлэх vр дvнтэй vйлчилгээг vзvvлж тэмбvv овчин илэрсэн тохиолдолд бэлгийн хавьтагчийн хамт эрvvлжvvлдэг эрvvл мэндийн цогц vйлчилгээг vзvvлж байна.Торолхийн тэмбvv овчин нь урьдчилан сэргийлж, эрт илрvvлж, бvрэн эмчлэгдэх боломжтой богоод та бvхэн эмнэлгийн эмч мэргэжилтнvvд бидэнтэй хамтран тэмбvv овчинтэй тэмцэх vйл ажиллагаанд нэгдэж чадвал тэмбvv овчноор овдохгvй, тvvний шалтгаант ураг нярайн

овчлол эндэгдлээс урьдчилан сэргийлж чадна.

## ТЭМБҮҮ ӨВЧНИЙ ТАЛААР ТА БҮХНИЙ МЭДЛЭГТ

Тэмбvv овчин нь цайвар трепонемаар vvсгэгддэг, хvний биеийн бvх эрхтэн систем арьс салст, дотор эрхтэн, мэдрэлийн систем ба тулгуур ходолгооний эрхтэнийг гэмтээдэг даамжрах явцтай бэлгийн замын архаг халдварт овчин юм.

**Ангилал:**

·1-р vеийн тэмбvv

·2-р vеийн тэмбvv

·3-р vеийн тэмбvv

·Далд тэмбvv

·Торолхийн тэмбvv

**Халдварлах зам:**

·Бэлгийн замаар

·Эхээс урагт

·Цусаар халдвар дамжина

**Нууц хугацаа:**

·Халдвар авснаас хойш 3-4 долоо хоногийн дараа эмнэл зvйн анхны шинж тэмдэг илэрнэ. Нууц хугацаа зарим vед 10-15 хоног хvртэл богиносч болох ба 108-190 хоногоор уртасч ч болно.

**I veийн тэмбvv** нь нууц vеийн хугацааны дараа анхны шинж тэмдэг болох овчин эмзэглэлгvй хатуу яр бэлэг эрхтэн тvvний орчим, бэлэг эрхтэнээс хол байрлалтай гарч, тvvний орчмын тунгалгийн булчирхай томрон, тунгалагийн судас vрэвсэх хэлбэрээр илрэн 6-7 долоо хоног vргэлжилнэ.

**II veийн тэмбvv** нь халдвар авснаас хойш 2-3 сарын дараа, хатуу яр гарснаас хойш 7-8 долоо хоногийн дараа арьс салстаар толбот, гvвдрvvт, идээт, цэврvvт тархмал тууралт гарахаас гадна vс унах, арьс цайх шинж тэмдгээр эхэлж 2-5 жил идэвхтэй болон далд хэлбэрээр vргэлжилнэ.

**III veийн тэмбvv** нь халдвар авснаас хойш 3-6 жилийн дараа арьс салстад товруу зангилаа зэрэг гvн байрласан тууралт гарахаас гадна дотор эрхтэн, мэдрэлийн системд гvнзгий оорчлолт илэрч , яс vе мочийг гэмтээн 5-10 жил тvvнээс дээш хугацаагаар vргэлжилнэ.

**Жирэмсэн vеийн тэмбvv өвчин:**

·Жирэмсэн эмэгтэй овчлохоос гадна ураг нярай халдварлаж, овчлох ондор эрсдэлтэй

·Тэмбvv овчний vvсгэгч нь ихсийн цусны эргэлтээр дамжин урагт халдварласнаар торолхийн тэмбvv овчнийг vvсгэнэ.

·Жирэмсний тэмбvv овчний улмаас амьгvй торох, дутуу торох, зулбах, жин багатай торох, нярай эндэх, торолхийн гаж хогжил vvсэх зэрэг хvндрэлvvдийг бий болгоно.

·Жирэмсний тэмбvv овчноос урьдчилан сэргийлэх, эрт илрvvлж оношлох зорилгоор ЭМС-ын 39 дvгээр тушаалын дагуу жирэмсний явцад анхны гэмтээхгvй.

·Эмчилгээ хийх явцдаа эмчийн заасан дэг журмыг сахиж согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгvй байх,

**Гаж хөгжил vvсэх зэрэг хvндрэлvvдийг бий болгоно.**

·Жирэмсний тэмбvv овчноос урьдчилан сэргийлэх, эрт илрvvлж оношлох зорилгоор ЭМС-ын 39 дvгээр тушаалын дагуу жирэмсний явцад анхны vзлэгээр болон 28-32 долоо хоногтойд та 2 удаа тэмбvvгийн сорилд хамрагдах ёстой.

·Таны нууц хадгалагдан vлдэх учир та санаа зоволтгvйгээр хяналтын эмчдээ холбогдох мэдээллийг огч бvрэн хянуулаарай.

**Тэмбvv өвчнөөс урьдчилан сэргийлэх:**

·Та эрvvл аж торох ёс, ариун цэвэр ялангуяа бэлгийн ариун цэвэр, эрvvл ахуйн дэглэм сахих, аюулгvй бэлгийн харьцаа, бэлгэвч хэрэглэх талаар мэдлэг, дадалтай болох.

·Жирэмсний хяналтад эрт хамрагдаж, тэмбvv илрvvлэх шинжилгээнд хамрагдах.

·Тэмбvv овчин илэрсэн тохиолдолд эмчийн хяналтад эмчилгээг цаг алдалгvй бvрэн тогс хийлгэж чадвал таны хvvхэд эрvvл торно.

·Бэлгийн хавьтагчаа заавал шинжилгээ, эмчилгээнд хамруулах.

·Тохиолдлын бэлгийн хавьталд хамгаалалтгvй орсон тохиолдолд заавал vзлэг шинжилгээнд хамрагдах.

·Шаардлагагvй хатгалтаас зайлсхийх.

·Дээрхи зовломжvvдийг хэрэгжvvлж чадвал та эрvvл байж vр удам тань эрvvл торж осч бойжих болно.

**Та vvнийг санаж яваарай!**

·Бэлгийн замаар дамжих халдварт овчнvvд нь оороо аяндаа эдгэдэггvй, дур мэдэн оорийгоо эмчлэх нь овчнийг архагшуулан ужиг хэлбэрт шилжvvлдэг гэдгийг санаарай.

·Та мэргэжлийн эмчийн заасан эмчилгээг цаг алдалгvй эхэлж, эмчилгээний тунг гvйцэд авснаар бvрэн эдгэрэх боломжтой, цаашид бусад эрхтэн системийг гэмтээхгvй.

·Эмчилгээ хийх явцдаа эмчийн заасан дэг журмыг сахиж согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгvй байх, бvрэн эдгэртэл бэлгийн хавьталд орохгvй байх зэрэг заалтуудыг биелvvлээрэй.

**“ЭРҮҮЛ МЭНД ЭРХЭМ БАЯН"**